

Мэдлэгийн Төвийн Удирдах зөвлөл

Удирдах зөвлөлийн чиг үүрэг

Удирдах зөвлөл нь Мэдлэгийн төвийг олон нийтэд төлөөлөх бөгөөд үүний тогтвортой хэрэгжилтийг баталгаажуулах удирдлага зөвлөмжөөр хангах, стратегийн чиглэл өгөх үүрэгтэй. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл:

- Мэдлэгийн төвийн стратегийн төлөвлөлт, бизнесийн үйл ажиллагааг тодорхойлно,
- Ажлын албад Мэдлэгийн төвийн үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөө, тогтвортой бизнесийн загвар боловсруулах, хяналт үнэлгээ хийхэд удирдамж чиглэл өгнө,
- Мэдлэгийн төвийн хөгжлийг дэмжих бодлогын баримт бичиг бэлтгэнэ,
- Хэрэгжүүлэх үе шатны төгсгөл хүртэл Мэдлэгийн төвийн үйл ажиллагааны ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг хянаж үнэлнэ,
- Харилцаа холбоо, маркетинг, хөрөнгө босгох гэх мэт бүх төрлийн асуудлаар Мэдлэгийн төвийн үүрэг хариуцлага, үйл ажиллагааны чанарын баталгаажуулалтыг хариуцна.

Удирдах зөвлөлийн хурлыг улиралд 1 удаа зохион байгуулах бөгөөд мэдлэгийн төвийн бодлого, зорилго, санхүүгийн зарцуулалтыг хянах, жилийн ажлын төлөвлөгөө, санхүүгийн хувиарлалт, үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээ гэх мэт гол асуудлаар ярилцаж удирдлагаар хангана. Мөн түүнчлэн удирдах зөвлөлийн дарга болон гишүүд Мэдлэгийн төвийн Ажлын албатай нягт холбоотой ажиллаж дэмжлэг үзүүлнэ.

Удирдах зөвлөлийн бүтэц

Мэдлэгийн төвийн Удирдах зөвлөлийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ) удирдана. Тогтвортой бичил уурхай төслийн Мэдлэгийн төв, харилцааны эксперт болон УУХҮЯ-ны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн нар Удирдах зөвлөлийн нарийн бичгийн үүргийг гүйцэтгэнэ. Удирдах зөвлөл нь Мэдлэгийн төвийн талаар шийдвэр гаргах гол бүрэлдэхүүн байна. Удирдах зөвлөл нь Монголын бичил уурхайн салбарыг хөгжүүлэх стратегийн зорилготой бичил уурхайн асуудал хариуцаж мэдлэг бий болгон ажилладаг цаашид ШХА-ийн дэмжлэг зогссоноос хойш Мэдлэгийн төвийн үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх сонирхол, эрмэлзэлтэй байгууллагуудын гишүүдээс бүрдэнэ.

Удирдах зөвлөл нь төрийн байгууллага, ТББ-ууд, иргэний нийгмийн байгууллага, донор/олон улсын байгууллагуудаас бүрдэнэ. Удирдах зөвлөлийн гишүүдийг бичил уурхайтай холбоотой дараах чиглэлийн чадвар, мэдлэг, сонирхол дээр тулгуурлаж сонгоно. Үүнд:

- Бичил уурхайн мэдлэг, туршлагатай
- Бичил уурхайн асуудлыг анхаарч ажиллах сонирхолтой
- Харилцаа холбоо, маркетинг, нөлөөлөл, хөрөнгө босгох, бизнесийн чиглэлээр мэдлэг туршлагатай

Удирдах зөвлөлийн гишүүд

1. Удирдах зөвлөлийн дарга, Уул уурхай, хүнд үйлдвэрийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Даваадорж
2. Удирдах зөвлөлийн гишүүн, Байгаль орчны яамны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга Г. Нямдаваа
3. Удирдах зөвлөлийн гишүүн, Ашигт малтмал газрын тосны газрын Геологи технологийн хэлтсийн дарга Б.Хангай
4. Удирдах зөвлөлийн гишүүн, Хүний Эрхийн Комиссын Ажлын албаны дарга Ч. Алтангэрэл

5. Удирдах зөвлөлийн гишүүн, MERIT төслийн удирдагч Синди Фэйр
6. Удирдах зөвлөлийн гишүүн, Хөгжлийн Шийдэл ТББ-ын Гүйцэтгэх захирал Э.Бат-Орших
7. Удирдах зөвлөлийн гишүүн, Тогтвортой бичил уурхай төслийн Үндэсний зохицуулагч Б. Алтанбагана
8. Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбооны Гүйцэтгэх захирал Д. Баярмаа
9. Швейцарийн хөгжлийн агентлагийн хөтөлбөрийн ажилтан Н. Эрдэнэсайхан

Удирдах зөвлөлийн зорилго

Мэдлэгийн төвийн Удирдах зөвлөл нь:

- Монголын мэдлэгийн төвийн Ажлын албыг мэдлэгийн төвийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж ажиллуулахад нь дэмжлэг үзүүлэх,
- Хамтрагч талуудын мэдлэг мэдээлэл хуваалцах, суралцах, чадавх бэхжүүлэх санаачлагуудыг дэмжих,
- Удирдах зөвлөлийн гишүүдийг мэдлэг бий болгох, хөгжүүлэх чиглэлээр дэмжих,
- Сэдэвчилсэн бүлгийн ахлагч нарын үйл ажиллагаанд үр дүнтэй, ач холбогдолтой хувь нэмэр оруулах, дэмжлэг үзүүлэх,
- Олон улсын Мэдлэгийн төвтэй холбоо тогтоож, хамтран ажиллах,

Үр дүн

Монголын мэдлэгийн төвийн Удирдах зөвлөл мэдлэгийн төвийн үйл ажиллагааг үр дүнтэй, амжилттай удирдаж хэрэгжүүлж бичил уурхайн талаар цэгцтэй тодорхой мэдлэг мэдээлэл бий болгоход оршино.

- Мэдлэгийн төвийн Удирдах зөвлөлийн гишүүд Сэдэвчилсэн бүлгүүдийн гишүүдтэй хамтарч ажиллах үр дүнтэй, нягт холбоотой ажиллах,
- Монголын бичил уурхайн мэдлэгийн төвийн үйл ажиллагааг Үндэсний болон Олон улсын түвшинд хүргэх,
- Монголын мэдлэгийн төвийн үйл ажиллагаагаар дамжуулан бичил уурхай талаарх олон нийтийн хандлага ойлголт эерэгээр өөрчлөгдөх,
- Монголын бичил уурхайн салбарт бүрдсэн сайн туршлага, сурсан сургамжыг олон улсын бичил уурхайн талбарт хүргэх,

Удирдах зөвлөлийн хурал

Удирдах зөвлөлийн хурлыг улиралд 1 удаа зохион байгуулах бөгөөд Мэдлэгийн төвийн ажлын явц, зорилт, бодлого, зорилго, санхүүгийн зарцуулалтыг хянах, жилийн ажлын төлөвлөгөө, санхүүгийн хувиарлалт, үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээ гэх гол асуудлаар ярилцаж удирдлагаар хангана. Мөн түүнчлэн удирдах зөвлөлийн дарга болон гишүүд Мэдлэгийн төвийн ажлын албатай хурлаас бусад үеэр нягт холбоотой ажиллаж дэмжлэг үзүүлнэ. Хурлаас хурал хүртэлх хугацаанд Удирдах зөвлөлийн гишүүн байгууллагууд болон сэдэвчилсэн бүлгийн ахлагч нарт Мэдлэгийн төвийн ажлын алба болон Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга хандаж зөвлөгөө, дэмжлэг хүсч болно.

Удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга бэлтгэх бөгөөд хуралд оролцсон гишүүдээр гарын үсэг зуруулж баталгаажуулна. Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга хурлын тэмдэглэлийн бүрэн эхийг хавсралтуудын хамт бүх гишүүдэд хүргэнэ.

Хэрэв Удирдах зөвлөлийн аль нэг гишүүн байгууллага эсвэл Сэдэвчилсэн бүлгийн ахлагч хуралд оролцох боломжгүй болсон тохиолдолд өөрийгөө орлон оролцох хүнийг томилж явуулна. Өөрийгөө орлуулж хүн томилсон тухай шийдвэрийг Удирдах

зөвлөлнө даргад хурал болохоос ажлын 3 өдрийн өмнө мэдэгдэнэ. Хуралд орлон оролцож байгаа хүн тухайн хурал дээр хэлэлцсэн асуудлаар санал өгөх эрхтэй байна.

Сэдэвчилсэн бүлгүүд

Мэдлэгийн төв нь дөрвөн үндсэн сэдвээр бүлэг байгуулан ажиллана. Сэдэвчилсэн бүлэг бүр дотроо бичил уурхайтай холбоотой дэд сэдэвтэй байна. Сэдвүүдийг тухайн чиглэлээр туршлагатай, мэдлэгтэй, сонирхолтой хүмүүс удирдана. Сэдэвчилсэн бүлгийн ахлагч нар Удирдах зөвлөлийн гишүүн байна. Сэдэвчилсэн бүлгийн үйл ажиллагааг Тогтвортой бичил уурхай төслийн экспертүүд дэмжиж ажиллана.

- **Бичил уурхайн хууль эрх зүйн орчин**
 - Зохион байгуулалт,
 - Уул уурхайн компаниуд ба бичил уурхайчдын байгууллагын хамтын ажиллагаа,
 - Хууль журам, бодлого боловсруулалт,
- **Хүний эрхэд сүүрилсэн хандлага ба албажуулалт**
 - Хүний эрх
 - Жендерийн тэгш байдал,
 - Оролцоо,
 - Мэргэшүүлэлт,
 - Албажуулалт,
- **Эдийн засгийн тогтвортой байдал, нийлүүлэлтийн сүлжээ**
 - Нийлүүлэлтийн сүлжээ,
 - Ашигт малтмалын борлуулалт,
 - Орон нутгийн эдийн засгийн хөгжил,
 - Амьжиргаа,
 - Бизнесийн хөгжил/эдийн засгийн боломж,
- **Байгаль орчин, аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд**
 - Мөнгөн усгүй технологи,
 - Байгаль орчны нөхөн сэргээлт,
 - Ажлын байрны аюулгүй ажиллагаа болон эрүүл мэнд,